

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БНА-2024/25-2-ШТА-ГА

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт боловсруулах, захиалагчийн хяналт тавих, ажлыг хүлээн авах зэрэгт мэргэжлийн байгууллага оролцохгүй байгаагаас ажлын чанар хангалтгүй, гүйцэтгэл дутуу, хийхгүй орхигдуулах зөрчил арилахгүй байна.

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу
Цахим хуудас: www.tailan.audit.mn

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор **Б.Мөнхбат**
Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер **М.Алтангуяа**
Утас: 70442424 цахим хуудас: -

Ахлах аудитор **Б.Должмаа**
Утас: : 70442424 цахим хуудас: dolimaab@audit.gov.mn
Аудитор **Д.Цэдэвцэвээн**
Утас: : 70442424 цахим хуудас: tsedevtseveend@audit.gov.mn

Аудитор **С.Цэвээнсүрэн**
Утас: : 70442424 цахим хуудас:

Баянхонгор хот 2024 он

Тайланг хянасан:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Тайланг бэлтгэсэн:

Аудитын менежер М.Алтантуяа

Ахлах аудитор Б.Должмаа

Аудитор Д.Цэдэвцэвээн

Аудитор С.Цэвээнсүрэн

2024 оны 06 дугаар сарын 14-ний өдөр

Тайланг УАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:
Үндэсний аудитын газар
Засгийн газрын IY байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот 15160
Монгол Улс

АГУУЛГА

БҮЛЭГ 1. БАЯНХОНГОР АЙМАГТ ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГААС ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙГ БАТАЛСАН ХУВААРИЙН ДАГУУ ОЛГООГҮЙ БАЙНА. 6

1.2. Иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталдаг зөрчил бүрэн арилахгүй байна. 9

БҮЛЭГ 2. САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫГ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГААР ХЯНУУЛААГҮЙ, ХИЙХ АЖЛЫГ НАРИЙВЧЛАН БОЛОВСРУУЛААГҮЙ, БАГЦ АРГА ХЭМЖЭЭ НЭРИЙН ДОР ТӨСӨВТ ӨРТГИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН НЬ АУДИТ ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХАД ТӨВӨГТЭЙ БАЙДЛЫГ ҮҮСГЭЖ БАЙНА. 13

2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчин зохион байгуулсан байна. 13

2.2. Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээнээс сумдад эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүн хангалтгүй байна. 16

2.3. ОНХС-ийн хөрөнгийн санхүүжүүлсэн мод, суулгац тарих ажлын үсалгааны асуудлыг бүрэн шийдээгүйгээс ургалтын байдал хангалтгүй байна. 19

БҮЛЭГ 3. АЙМАГ, СУМДЫН ИТХ, ЗДТГ-УУД ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТЫГ ТАВЬЖ, ТАЙЛАГНАХ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА. 21

3.1. ОНХС-ийн үйл ажиллагаанд бүх шатны ИТХ-аас төсөл, арга хэмжээний хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. 21

3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээ, бодлогыг тодорхойлж ажиллахгүй байна. 23

ДҮГНЭЛТ 28

ЗӨВЛӨМЖ 29

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЗЗНДНТУТХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
МЭГ	Мал эмнэлгийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТАХ	Төсөл, арга хэмжээ
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХДАА	Санхүүгийн хяналт дотоод аудитын алба
УМС	Удирдлага мэдээллийн систем
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

Хүлээн авсан баримтын жагсаалт

Байгууллагын нэр	Ирүүлсэн баримтын нэр
Баянхонгор аймгийн ЗДТГ	- ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн санхүүжилтийн эрх (сараар) - Аймгийн ЗДТГ-аас сумдад олгох ОНХС-ийн сар, улирлын хуваарь - ОНХС-ийн 2023 оны дансны хуулга - ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд - Нэгдсэн судалгаа
Сумдын ЗДТГ	- Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт - Нэгдсэн судалгаа - Сумын ОНХС-ийн дансны хуулга - ОНХС-ийн анхан шатны баримтууд

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх
Аудитын зорилт
Аудитын хамарсан хүрээ
Аудитын арга зүй

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны А/152 дугаар тушаал, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторов “Аудитын жилийн төлөвлөгөө батлах” тухай 2024 оны А/1 дүгээр тушаалын дагуу аудитыг гүйцэтгэв.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэв.

Аудитын зорилгыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.

Аудитад Баянхонгор аймгийн болон 20 сумын ОНХС-ийн 2023 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал болон аймаг, сумын ИТХ, ЗДТГ, баг, хороодын ИНХ, Засаг даргын холбогдох үйл ажиллагааг хамруулан шалгалаа.

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулж ажиллав.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /2020 он/;
- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”;
- Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолуудаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд;
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Хүндрэл бэрхшээл

- Аймаг, сумдын ОНХС хариуцсан холбогдох албан тушаалтнууд солигдсон;
- Аудитын явцад аудитын багийн 1 гишүүн ажлаас чөлөөлөгдсөн тул багт өөрчлөлт орж, шинээр аудитор томилогдсон;
- Аудитын багийн 1 аудитор аудитын явцад урт хугацаагаар өвдсөн зэрэг хүндрэл аудитын явцад гарсан.
- Баянхонгор аймгийн ОНХС-аас Баянхонгор сумын ОНХС-д эрх шилжүүлэн олгосон төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг аудитаар шалгахад ажлууд давхардсан, 2022 оны ажлын гүйцэтгэлтэй давхардсан, зарим материал тооллогоор дутагдсан зэргийг эргэн нягтлан шалгахад цаг хугацаа их шаардсан болно.

БҮЛЭГ 1. БАЯНХОНГОР АЙМАГТ ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГААС ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙГ БАТАЛСАН ХУВААРИЙН ДАГУУ ОЛГООГҮЙ БАЙНА.

1.1. ОНХНС-аас Баянхонгор аймгийн ОНХС-д 15,405.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас 15,192.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, 212.9 сая төгрөгийн санхүүжилт дутуу хуваарилсан, орлогын шилжүүлгийг баталсан боловч хуваарийн дагуу олгоогүй байна.

1.1.2. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд улсын төсвөөс Баянхонгор аймагт ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг 12,601.5 сая төгрөгөөр баталсан байна.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл нэмэгдсэнтэй холбоотойгоор Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулж, Баянхонгор аймагт ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг 2,803.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 15,405.3 сая төгрөгийг олгохоор хуульчилсан байна.

Хүснэгт 1. ОНХНС-аас олгохоор баталсан дүн (сая.төг)

№	Эх үүсвэр	Анхны төлөвлөгөө	2023 он	
			Нэмж тодотгосон төлөвлөгөө	Хувь
1	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	9,666.0	12,469.8	80.9
2	Газрын тосны нөөц ашигласны төлбөр	647.2	647.2	4.2
3	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл	194.7	194.7	1.3
4	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл	1,136.4	1,136.4	7.4
5	Олон Улсын төсөл хөтөлбөрөөс сумдын ОНХС-д олгох урамшуулал	957.2	957.2	6.2
ДҮН		12,601.5	15,405.3	100.0

Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, хуулийн нэмэлт өөрчлөлт, Сангийн сайдын тушаалууд

Сангийн яамнаас Баянхонгор аймагт олгох орлогын шилжүүлгийн сар, улирлын хуваарийг баталж гаргасан боловч баталсан дүнгээс сар бүрийн төлөвлөгөөт хуваарийн дагуу шилжүүлээгүй, 2023 оны эхний хагас жилд олгохоор тооцсон санхүүжилтээс 1,341.9 сая төгрөгийг дутуу олгож, сүүлийн хагас жилд нөхөн олгосон байна.

ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д санхүүжилтийг хоцроож олгосонтой холбоотой бөгөөд сүүлийн хагас жилд нийт санхүүжилтийн ихэнх хувийг олгосон нь төлөвлөсөн арга хэмжээ цаг хугацаандаа хэрэгжихгүй байх, он дамжих, хэрэгжих боломжгүй болох эрсдэлтэй байна.

Баянхонгор аймагт ОНХНС-аас 2023 онд олгохоор баталсан орлогын шилжүүлгээс 15,192.4 сая төгрөгийг олгон, 212.9 сая төгрөгийг дутуу олгосон нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого тасарснаас шалтгаалжээ.

Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт Нэгдсэн тайланд оруулах санал:
• ОНХНС-аас аймагт олгохоор баталсан санхүүжилтийг баталсан хуваарийн дагуу бүрэн олгох асуудлыг тусгах нь зүйтэй байна.

1.1.3. Баянхонгор аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3¹ дахь заалт, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн

¹ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно:

хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу Баянхонгор аймагт хуваарилагдсан 15,405.3 сая төгрөгийн орлогын шилжүүлгээс 7,072.9 (45.9%) сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 8,332.4 (54.1%) сая төгрөгийг 20 сумын ОНХС-д хуваарилж, нэгдүгээр сараас бусад саруудад олгох шилжүүлгийн дүнг баталсан байна.

Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлалаар сумдад хөрөнгийг хуваарилсан бол олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал нь гүйцэтгэлийн үнэлгээгээр, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн орлого нь тухайн сумын ОНХС-ийн үйл ажиллагаа, тухайн нутагт байрлах тусгай зөвшөөрлөөс хамаарч харилцан адилгүй хуваарилагдсан байна.

Сумдад баталсан 8,332.4 сая төгрөгийн орлогын шилжүүлгийн 1,091.1 сая төгрөгийг Баянхонгор суманд баталсан нь нийт шилжүүлгийн 13.3 хувийг эзэлж байгаа бол Шинэжинст, Баян-Өндөр, Баянлиг сумдад 7.1-8.8 хувь, Баянговь, Баянцагаан, Бууцагаан сумдад 5-6.9 хувийг олгосон бөгөөд Баян-Овоо, Жинст сумдад 2.6-2.7 хувийг олгосон нь хамгийн бага хувийг эзэлж байна.

Улсын хэмжээнд жилийн эцэст ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тасарснаас шалтгаалж, санхүүжилт 212.9 сая төгрөгөөр дутуу ирсэн тул сумдад олгох улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлгийг 175.1 сая, ОНХС-ийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийг 3 суманд 37.8 сая төгрөгөөр дутуу олгожээ.

1.1.4. Баянхонгор аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасны дагуу төлөвлөхдөө хандивыг өндрөөр тооцсон, жилийн дундуур нэмж тодотгон төлөвлөсөн нь орлого тасрах гол шалтгаан болжээ.

Баянхонгор аймаг, сумдын ИТХ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 болон “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын 2.2-т заасны дагуу 2023 онд ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг 25,252.2 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 2. ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэр (сая.төг)

№	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Эзлэх хувь
1	ОНХС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг	13,631.4	54.0
2	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 100% /ТТХ-ийн 60.2.7 орсон/	171.9	0.7
3	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 50% /ТТХ-ийн 60.2.7 орсон/	644.8	2.6
4	"Тогтвортой амьжиргаа-3" төсөл /ТТХ-ийн 59.1.3/ урамшуулал	957.2	3.8
5	ИТХ-ын тогтоолоор баталсан ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл	2,855.3	11.2
6	ТТХ-ийн 60.2.5 "тухайн ОНХ-ийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив тусламж, ОУБ-ийн төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг"	3,914.8	15.5
7	Малын тоо толгойн татвар	1,566.1	6.2
8	Бусад орлого	1,510.7	6.0
ДҮН		25,252.2	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймаг, сумдын ИТХ-ын тогтоолууд

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.3²-т заасны дагуу орон нутагт тэргүүлэх шаардлагатай хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, түүнд засаглал болон иргэд, олон нийтийн оролцоог сайжруулах зорилго бүхий “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс

² орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;

Баянхонгор аймгийн сумдын ОНХС-ийн үйл ажиллагааг 5 үзүүлэлтээр дүгнэж, үзүүлэлтийг үндэслэн олгох урамшууллыг тодорхойлсон байна.

“Тогтвортой амьжиргаа-3” төслийн цахим хуудаснаас (mof.gov.mn) Баянхонгор аймагт 2021 онд бүх сумд 580.0 сая, 2022 онд 704.2 сая төгрөгийн урамшуулал авсан бол 2023 онд өмнөх онуудаас санхүүжилт өсөж 957.2 сая төгрөгийн санхүүжилт авсан хэдий ч Баацагаан, Баян-Овоо, Жаргалант, Жинст сумд ажлын үзүүлэлтээрээ урамшуулал авч чадаагүй байна. Иймд эдгээр сумдын ОНХС хариуцсан холбогдох мэргэжилтнүүд ажлын хариуцлагаа дээшлүүлэх нь зүйтэй байна.

Баянхонгор аймгийн Татварын газраас үүсгэсэн малчин өрх мал бүхий 15,524 татвар төлөгчөөс 1,566.1 сая төгрөгийн малын тоо толгойн албан татварыг оруулахаар сумдын ИТХ-аар баталж, гүйцэтгэлээр 1,301.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, орлогын гүйцэтгэл 83.1 хувьтай байна.

Баянлиг, Жинст, Баянговь, Гурванбулаг, Заг, Баянбулаг сумд малын тоо толгойн албан татварын төлөвлөгөөг давуулан биелүүлж, бусад сумд орлогын төлөвлөгөө тасарчээ. Цаашид орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, бэлчээрийн ашиглалт, цөлжилт, худаг усны хангамж зэрэг асуудлыг шийдвэрлэх боломжийг бүрэн ашиглах шаардлагатай байгаа тул сумд малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажиллах нь зүйтэй байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5³-т заасны дагуу аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор 2023 онд 3,914.8 сая төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,472.4 сая төгрөгийг уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс орж, орлогын төлөвлөгөө 1,442.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай” гэрээний загварын 2.1.3 дахь хэсэг, холбогдох хуулиудыг үндэслэн аймгийн Засаг дарга “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай” гэрээг тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй харилцан тохиролцож уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг 9 аж ахуйн нэгжтэй “Орон нутгийн хамтын ажиллагааны” гэрээ байгуулсан байна.

Эдгээр гэрээг үндэслэн аймгийн ОНХС-д анх 2,568.1 сая төгрөгийг оруулахаар баталж, төсвийн тодотголоор 730.0 сая төгрөгийг нэмэгдүүлж, 3,298.1 сая төгрөгөөр баталсан нь “Эрдэнэ монгол” ХХК-ийн 2024 онд гэрээгээр төлөх 730.0 сая төгрөгийг урьдчилж авсантай холбоотой байна. Гүйцэтгэлээр уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдээс 2,180.0 сая төгрөгийн орлого орж, орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Харин сумдын хувьд Галуут сум 137.7 сая, Баян-Овоо сум 179.0 сая, Шинэжинст сум 300.0 сая төгрөгийг оруулахаар төлөвлөж, Галуут сумаас бусад сумдад хандивын орлого төлөвлөсөн хэмжээнд орсон байна.

Аймгийн ОНХС өмнөх онуудад олгосон зураг төсвийн орлогоос 250.0 сая, сумдын ИТХ-ын тогтоолоор өмнөх онуудад олгосон өвс тэжээлийн орлогоор 1,260.6 сая төгрөгийг оруулахаар төлөвлөснийг Баянлиг, Хүрээмарал, Шинэжинст сумд биелүүлж ажиллаагүй байна.

³ “ тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг”


1.2. Иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталдаг зөрчил бүрэн арилахгүй байна.

1.2.1. Цахим технологийг ашиглан “Тогтвортой амьжиргаа 3” төслийн хүрээнд бий болсон санал өгөх апплекшнийг иргэд ашиглаж санал өгч байгаа боловч иргэний оруулсан санал бусад иргэдэд харагдахгүй байгаагаас иргэний санал дэмжигдэхгүй, хүртээмжтэй байдлаар эрэмбэлээгүйгээс 37 иргэний 1,350.3 сая төгрөгийн санал дэмжигдээгүй байна.


Сангийн яам, “Тогтвортой амьжиргаа 3” төслөөс хэрэгжүүлсэн сургалтын үр дүн, санал өгөх аппликейшнийг иргэд ашиглаж дадсан зэргээс шалтгаалж, баг, сумын түвшинд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг журмын дагуу авч байгаа сайн талтай байна.

Аудитын үед иргэдээс “Та 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд саналаа өгсөн үү?” гэсэн асуултад санал асуулга авахад нийт оролцогчийн 63.8 хувь нь өгсөн байгаа нь өмнөх аудитаар авсан санал асуулгын дүнгээс 25.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Та Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх холбогдох хууль, тогтоомж, журмыг судалж үзсэн үү?




Орон нутгийн хөгжлийн сангийн талаар та хэр мэдээлэлтэй вэ?



Санал асуулгад оролцогчдын 52.1 хувь нь ОНХС-ийн талаар “Хангалттай” мэдээлэл авдаг, 48.6 хувь нь ОНХС-ийн талаарх хууль, тогтоомж, журмыг судалсан гэж хариулснаас харахад өмнөх жилүүдээс иргэдийн мэдээ, мэдээлэл, идэвхи оролцоо нэмэгдсэн нь харагдаж байна.

Та 2023 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд саналаа өгсөн үү?



Санал асуулгаар нийт оролцогчдын 63.8 хувь нь 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд саналаа өгсөн гэж хариулсан ба санал өгсөн байна.

Иргэд, олон нийтээс ОНХС-ийн аппликейшн, Удирдлагын мэдээллийн системээр дамжуулан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг авсан ба сумдын багийн Засаг дарга нар хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг явуулж, аймгийн дүнгээр нийт 90,373 иргэнээс санал авсан байна.

Санал асуулгад оролцсон 90,373 иргэнээс давхардсан тоогоор нийт 32,945.1 сая төгрөгийн 548 ажлын санал ирснээс 93.7 хувь буюу 23,192.7 сая төгрөгийн 506 саналыг дэмжиж, 37 иргэний 1,350.3 сая төгрөгийн санал дэмжигдээгүй байна.

Өмнөх оны аудитаар “Хамтын удирдлага гэсэн нэрийн дор иргэдээс санал аваагүй төсөл, арга хэмжээг ИТХ-аар батлахгүй байх” зөвлөмжийг аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дарга нарт хүргүүлсэн хэдий ч иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталж буй зөрчил бүрэн арилаагүйгээс аймгийн ОНХС-ийн 2,855.8 сая төгрөгийн 44 төсөл арга хэмжээ, 3 сумын 540.6 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээ, нийт 3,396.4 сая төгрөгийн 53 төсөл арга хэмжээг иргэдийн санал аваагүй аймаг, сумын ИТХ-ын хуралдаанаар баталсан байна.

Аудитын илрүүлэлт

- Баянхонгор аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 15/42 дугаар тогтоолоор 2023 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг батлахдаа иргэдээс санал аваагүй 2,855.8 сая төгрөгийн 44 төсөл арга хэмжээг баталсан;
- Баян-Овоо сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын 2023 оны төсөв батлах тухай” 08/01 дугаар тогтоолоор Баян-Овоо сумын 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр иргэдээс санал аваагүй 490.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан;
- Эрдэнэцогт сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээг батлахдаа иргэдийн санал аваагүй “гудамж хорооллын өнгө үзэмжийг сайжруулах” 20.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг баталсан;
- Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр 5.1 сая төгрөгийн төсөвтэй “Малын чанарыг сайжруулах”, 15.6 сая төгрөгийн төсөвтэй “Тэжээлийн нөөц бүрдүүлэх”, 5.0 сая төгрөгийн төсөвтэй “Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа”, 4.9 сая төгрөгийн төсөвтэй “Малын эрүүл мэндийг хамгаалах” нийт 30.6 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг иргэдийн саналгүйгээр баталсан;

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5⁴, 16 дугаар зүйлийн 16.5.5⁵, 60 дугаар зүйлийн 60.3.6⁶ дахь заалтууд, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.2⁷, 4.7.5⁸ заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд цаашид зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг аймаг, сумын Засаг дарга нарт хүргүүлэв.

Цахим технологийг ашиглан “Тогтвортой амьжиргаа 3” төслийн хүрээнд бий болсон санал өгөх аппликейшнийг иргэд ашиглаж санал өгч байгаа боловч иргэний оруулсан санал бусад иргэдэд харагдахгүй байгаагаас иргэний санал дэмжигдэхгүй байна.

Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт Нэгдсэн тайланд оруулах санал:

- ОНХС-ийн гар утасны аппликейшнд иргэнээс өгсөн саналыг шууд нэмэгдэж, бусад иргэдэд тухайн санал харагдаж, санал өгөх боломжийг олгох хөгжүүлэлтийг хийх асуудлыг тусгах нь зүйтэй байна.

1.2.2. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9⁹, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2¹⁰, 63.3¹¹, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар

4 “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: хариуцлагатай байх

5 “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

6 “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно: орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ

7 “Сум, дүүргийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх

8 “Энэ зүйлийн 4.6-д зааснаар ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах зөвшөөрөхгүй зардалд дараах хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй: Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ

9 “Богдино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв хамаарна.

10 Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

11 Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.1¹², Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.4¹³-т заасныг үндэслэн аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан баталсан байна.

1.2.3. Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх 1 төсөл арга хэмжээг Төсвийн тухай хууль, барилгын төсөв зохиох дүрмийг зөрчиж төлөвлөсөн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээнээс Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6¹⁴, 29 дүгээр зүйлийн 29.4¹⁵ заалтыг зөрчин зураг төсөв батлаагүй, ТЭЗҮ хийлгээгүй, шаардагдах хөрөнгийг тооцоогүй, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, хэрхэн шийдвэрлэх тухай санал тусгаагүй 44.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг баталсан зөрчилтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор сумын 2023 онд хийгдэх ажлын зураг төсвийг 20.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр “Төгс орхон” ХХК-тай гэрээ байгуулсан бөгөөд ажлын төсөвт өртгийн товчоонд захиалагчийн техник хяналтын зардал, магадлашгүй ажил, зураг төсвийн үнийг тооцоогүйгээс захиалагчийн хяналт хийгдээгүй, холбогдох зардлуудыг илүү санхүүжүүлсэн байна.

Иймд Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 30 дугаар тушаалаар баталсан “Барилгын төсөв зохиох дүрэм”-ийг баримталж, холбогдох зардлуудыг тухайн төсөл, арга хэмжээний төсөвт багтаан төлөвлөх албан шаардлага хүргүүлж, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах 40.0 сая төгрөгийн 2 албан шаардлага, 4.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов.

Аудитаар Баянхонгор аймгийн иргэдээс авсан санал асуулгаар 37.8 хувь нь иргэдийн нэн тэргүүний хэрэгцээ, шаардлагад бүрэн нийцсэн ажлыг, 52.6 хувь нь зарим ажил нь хэрэгцээ, шаардлагад нийцсэн ажлыг гүйцэтгэж байгаа, 3.6 хувь нийцээгүй гэж хариулсан бөгөөд ОНХС-ийн 2023 онд баталж хэрэгжүүлсэн бүтээн байгуулалтын ажлууд нь орон нутгийн хөгжлийн дэмжсэн гэж нийт оролцогчийн 48.9 хувь нь хариулсан байгаагаас харахад иргэдийн ОНХС-аар хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний мэдлэг, хяналт нэмэгдсэнтэй холбоотой байна.


¹² Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

¹³ Орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байх;


¹⁴ Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ.

¹⁵ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

Танай орон нутгийн иргэдийн нэн тэргүүний хэрэгцээ шаардлагад нийцсэн ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэж байна уу?



ОНХС-н 2023 онд баталсан хөрөнгөөр хэрэгжүүлсэн бүтээн байгуулалтууд нь орон нутгийн хөгжлийг дэмжсэн үр дүнтэй ажил болсон уу?



1.2.4. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр төсөвт байгууллагуудын урсгал зардал, тоног төхөөрөмж авах төсөл арга хэмжээг баталж, хууль, тогтоомжийг зөрчсөн байна.

Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 9,224.7 сая төгрөгийн 90 төсөл арга хэмжээний 5,198.9 сая төгрөгийн 54 төсөл арга хэмжээ нь иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёлын арга хэмжээнд, 2,084.1 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээ нь дэд бүтцийг сайжруулахад, 976.8 сая төгрөгийн 16 төсөл арга хэмжээ нь орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулахад, 156.5 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ нь ундны усан хангамжийг сайжруулахад, 171.6 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ нь ТЭЗҮ, зураг төсөв боловсруулахад, 369.3 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ нь ажлын байрыг бий болгоход чиглэсэн байна.

Гэвч аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг батлахдаа хэт жижиг олон төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь орон нутагт томоохон хөрөнгө оруулалт бий болох боломжийг хаах эрсдэлтэй байна.

Сумдын ОНХС-ийн дүнгээр 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 11,716.2 сая төгрөгийн 432 төсөл арга хэмжээ, үүнд Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, Инновац, шинжлэн ухаан, цахим технологийг санхүүжүүлэхэд 2,861.6 сая төгрөгийн 82, дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээний ажилд 2,437.1 сая төгрөгийн 70, Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах 2,174.8 сая төгрөгийн 114, журамд нийцсэн бусад чиг үүргийн 2,933.6 төгрөгийн 110 төсөл, арга хэмжээ баталсан нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.4¹⁶-т заасныг хангасан байна.

Аудитын илрүүлэлт:

- Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйлчилгээний чанарыг сайжруулж, цахим мэдээллийн нэгдсэн системийн хөгжүүлэлт хийх, тоног төхөөрөмж худалдан авахад 270.0 сая төгрөг баталж, 267.5 сая төгрөг зарцуулсан байна.
- Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр Өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалтад 20.0 сая төгрөг баталж, үүнээс “Баянхонгор таймс” сонинд 1.0 сая төгрөг “Баянхонгор телевиз”-д 6.0 сая, “Өнөөгийн Баянхонгор” сонинд 3.0 сая төгрөгийг гэрээний дагуу шилжүүлж, иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг баталсан бөгөөд гэрээг дүгнэж ажиллаагүй, ямар ажил хийсэн нь тодорхой бус байна.

¹⁶ Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгаадаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

Дээрх зөрчил нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2 дахь заалттай нийцэхгүй байна.

Иймд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хууль, тогтоомжид нийцүүлэн төлөвлөх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлж, Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр чиг үүрэгт хамааралгүй төсөл, арга хэмжээ санхүүжүүлсэн 10.0 сая төгрөгийн урсгал зардлыг Баян-Овоо сумын ЗДТГ-ын төсвөөс төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

БҮЛЭГ 2. САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫГ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГААР ХЯНУУЛААГҮЙ, ХИЙХ АЖЛЫГ НАРИЙВЧЛАН БОЛОВСРУУЛААГҮЙ, БАГЦ АРГА ХЭМЖЭЭ НЭРИЙН ДОР ТӨСӨВТ ӨРТГИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН НЬ АУДИТ ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХАД ТӨВӨГТЭЙ БАЙДЛЫГ ҮҮСГЭЖ БАЙНА.

2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчин зохион байгуулсан байна.

2.1.1. Баянхонгор аймаг, сумын хэмжээнд 2023 онд шинээр хэрэгжих 20,545.7 сая төгрөгийн 438 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас 10,797.7 сая төгрөгийн 53 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 4,307.4 сая төгрөгийн 84 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар шалгаруулж, 5,349.7 сая төгрөгийн 298 төсөл, арга хэмжээнд гэрээ шууд байгуулж, Богд сум 91.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн байна.

Баянхонгор аймаг болон Богд, Баянхонгор, Бууцагаан, Гурванбулаг, Баянлиг сумдын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, техникийн тодорхойлолтод заагаагүй хөрөнгө худалдан авч ТБОНӨХӨАТҮХАТ-ийн 7.1.2, 15.3.3, 16.1.1, 16.1.4, 46.1.7, 57.4 заалтыг тус тус зөрчсөн 502.8 сая төгрөгийн 7 зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах 3 албан шаардлага, холбогдох буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох 2 албан шаардлагыг хүргүүлж, аймгийн Засаг дарга, Бууцагаан сумын Засаг дарга нарт зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт:

- Богд сумын ИТХ-ын тогтоолоор Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, тоглоомын талбай байгуулах ажилд 27.0 сая, цэцэрлэгийн тоглоомын засвар тохижилтод 26.5 сая, Соёлын төвд тайз засварын ажилд 37.5 сая төгрөгийг баталсан атлаа 20.0 сая төгрөгөөс бага үнийн дүнтэй гэрээг 2-3 иргэнтэй төсөл, арга хэмжээг хижиглэн шууд гэрээ байгуулсан;
- Баянхонгор сум "Ахмадын цэцэрлэгт хүрээлэн, сүүдрэвчтэй болгох /13,14-р байранд/" 50.0 сая төгрөгийн тендерт ТӨӨЗ-ны 1.1.10 дахь заалт "Сүүлийн 1 жилийн буюу 2022 оны борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна" заалтыг хангаагүй компани шалгаруулсан;
- Баянлиг сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан "Хогны ачих машин худалдах авах" 66.8 сая төгрөгийн гэрээг байгуулж гэрээний техникийн тодорхойлолтод заасны дагуу моторын багтаамж 6000-8000 байх гэж заасан боловч гүйцэтгэгч компаниас хүлээлгэн өгөхдөө моторын багтаамж 4720, С,Евро3 багтаамжтай ба энэ нь ачааны машин, хог ачих авто машины моторын багтаамж өөр байх ёстой техникийн тодорхойлолтоор ачааны машины багтаамжтай байхад хүлээн авах комисс акт үйлдэн хүлээн авсан;
- Гурванбулаг сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хэрэгжих "Цаг уурын талбайг стандартын болгох" 97.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаж, "Нью бест" ХХК-ийг 12.2 сая төгрөгийн татварын өртэй тендерийн ерөнхий нөхцөл хангаагүй байхад шалгаруулсан;
- Бууцагаан сумын ОНХС-аар 2023 онд Жишиг гудамж талбайтай болох 50.0 сая төгрөг, Хүүхдийн тоглоомын талбай барих 55.0 сая төгрөгийн тендер зарлаж, хамгийн бага санал

ирүүлсэн оролцогчийг сонгоогүй өөрийн сумын харьяа гэсэн шалтгаанаар “Онийн булаг”, “Сү Чо Ба Даймонд” ХХК-ийг шалгаруулсан;

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2023-2024 онд хэрэгжих Номундалай цогцолбор сургуулийн гадна спорт талбай байгуулах 1,324.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2023 онд 240.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй ажлын тендертэй холбоотой гомдлыг шийдвэрлээгүй байхад гэрээ байгуулсан байна.
- Бууцагаан сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 286.1 сая төгрөгийн төсөвтэй Шинэ сумын барилгын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт шаардлага хангаагүй оролцогчийг дахин шалгаруулсан байна.
- “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын багц 1 буюу 167.3 сая төгрөгийн Эрдэнэмандал хайрханы 3 га талбайд гоёлын мод, бут тарих ажлын тендерт шалгарсан Их хайрханы хаялага ХХК-нь нийгмийн даатгалын мэдээллийн санд бүртгэлгүй байхад тендерт шалгаруулсан байна.
- Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны материалыг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй.

2.1.2. Баян-Овоо сум нь гэрээг дүгнэж ажлаа хүлээлгэн өгсний дараа үлдэгдэл санхүүжилтийг олгохоор гэрээнд заасан боловч урьдчилж олгосон, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, санхүүжилтийг бүрэн авсан боловч ажлын гүйцэтгэл хангалтгүй байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд нийт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 20,603.2 сая төгрөгийн 375 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэнээс 1,954.1 сая төгрөгийн 20 төсөл арга хэмжээний санхүүжилтийг дутуу олгосон, бүрэн хэрэгжээгүй 11,818.5 сая төгрөгийн 56, огт хэрэгжээгүй 1,873.0 сая төгрөгийн 66 төсөл арга хэмжээ байна.

Тухайлбал: Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 80.0 сая төгрөгийн “Ид шидийн орон Баянхонгор” төслийн урсгал зардал, 112.4 сая төгрөгийн Бууцагаан сумын хуучин сургуулийн спорт заалны засвар, аймгийн ХХААГ-ын уулзвараас Онцгой байдлын газрын уулзвар хүртэл гэрэлтүүлэг хийх ажилд баталсан 20.0 сая төгрөгийн ажлууд хэрэгжээгүй, аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр төлөвлөсөн хандивын орлого тасарсантай холбоотойгоор “Баян-Овоо сумын хуучин цэцэрлэгийг засварлаж ахмадын ордон”-ны 30.0 сая, Баянлиг сумын сургуулийн засварын ажлын 107.0 сая, нийт 137.0 сая төгрөгийг олгоогүй, Баянхонгор сумын 6 дугаар багийн төвийн гадна тохижилтын ажилд 12.0 сая төгрөгийг дутуу шилжүүлсэн гэх мэт хэрэгжээгүй ажлууд байна.

Харин сумдын төлөвлөсөн арга хэмжээнээс 1,733.1 сая төгрөгийн 65 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Энэ нь малын тоо толгойн албан татвар тасарснаас эх үүсвэр бүрдээгүй, төсөвт өртөг хүрэлцээгүй, тендерт оролцогч ирээгүй зэргээс шалтгаалжээ.

Баянхонгор аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг шалгахад дараах нийтлэг зөрчил байна. Үүнд:

- Санхүүжилтийг олгосон байхад ажлыг дутуу, чанаргүй гүйцэтгэсэн
- Гэрээний үнийн дүнгээс илүү санхүүжилт олгосон
- Санхүүжилтийг авсан атлаа ажлыг гүйцэтгээгүй
- Гэрээг дүгнэж ажлаа хүлээлгэн өгсний дараа санхүүжилтийг олгохоор гэрээнд заасныг баримтлаагүй
- Сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн :

- Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүжин театрт 300 ширхэг үзэгчдийн суудлыг нийлүүлэх гэрээнээс 7,8 сая төгрөгийн 50 ширхэг сандлыг нийлүүлээгүй;
- Баянхонгор аймгийн Засаг даргын 2023.07.06-ны өдрийн А/372 дугаар “Аймгийн баяр наадамд хөрөнгө зарцуулах тухай” захирамжаар баяр наадмын зардалд 20.0 сая төгрөгийг олгосон бөгөөд санхүүгийн баримтад анхан шатны баримтыг хавсаргаагүй;
- Баянхонгор аймгийн ОНХС-аас аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/104 дүгээр захирамжаар аймгийн ЗДТГ-т Чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэхтэй холбоотой албан хаагчдын сургалтын төлбөрт 4.0 сая төгрөгийг олгосон;

Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн :

- "Нийтийн эзэмшлийн талбайд эко 00 нэмэгдүүлэх" төсөл арга хэмжээнд 12,6 сая төгрөгийн эх үүсвэр баталж, гүйцэтгэлээр 13.0 сая төгрөгийг олгож 0.5 сая төгрөгийг гүйцэтгэгч компанид илүү шилжүүлсэн;
- Баянхонгор сумын нутаг дэвсгэрт "Камержуулалт" хийх төсөл арга хэмжээнд 30.6 сая төгрөгийн эх үүсвэр баталж, гүйцэтгэлээр 34.1 сая төгрөг олгож, 3.5 сая төгрөг илүү олгосон;
- Тендерийн төсөвт тусгагдсан магадлалгүй ажлын зардлын тайлан ирүүлээгүй Хог хаягдлыг бууруулах "Дахивар хогийн цэг барих ажилд 0.4 сая, 13, 14 дүгээр байрны тохижилтын ажилд 0.8 сая төгрөг, нийт 1.2 сая төгрөгийг илүү олгосон;
- Баянхонгор сум "Ахмадын цэцэрлэгт хүрээлэн, сүүдрэвчтэй болгох /13,14-р байранд/" ажлыг 49.5 сая төгрөгөөр гүйцэтгэхээр "Мөнх ган оюу" ХХК-тай гэрээ байгуулсан бөгөөд техникийн тодорхойлолтод тусгагдсан орцны шатны налуу гаргах 8 ширхэг, орцны өрлөг, засвар хийх 1 ширхэг, явган замын хашлага /зурагт заагдсанаар/, худгийн таг 5 ширхэг, гадна гэрэлтүүлэг 6 ширхэг, модон сандал 10 ширхэг, гацуур модны суулгац 20 ширхэг зэрэг ажлууд хийгдээгүй;
- 2022 онд хийгдсэн Баянхонгор аймгийн 80 жилийн ойн бүтээн байгуулалтын ажлын өглөгийн үлдэгдлийг 130.0 сая төгрөгийн төсөвтэй "Баянхонгор сумын нутаг дэвсгэрт засварлах нэн шаардлагатай явган зам, эко хавтан суурилуулах" 10 төсөл, арга хэмжээ нэрээр 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн төсөвт тусгагдахдаа ажлын хэсэг томилж зураглал хийж тус ажлыг үнэлж баталгаажуулаагүй, тухайн хийгдсэн ажлыг хариуцаж байсан хуулийн этгээдээс нь хүлээн авснаа тодорхой тайлагнаагүй байна.

Өлзийт сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн:

- Гудамж талбайн гэрэлтүүлгийн ажлыг техникийн тодорхойлолтод тулган шалгахад "Орох хаалгыг тохижуулан 2 талд 6 ширхэг гоёлын мод байх", "гэрэлтүүлгийн баганыг 4 метрийн хоорондын зайтай 11 ширхэг, өндөр 5 м, өргөн 25 метрийн хэмжээтэй 75 тн-аар хийсэн 11 ширхэг багана байна" зэрэг 1.1 сая төгрөгийн ажил хийгээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон;
- Өлзийт сумын зөөврийн бие засах газрын техникийн тодорхойлолтод заасан эрэгтэй, эмэгтэй тасалгаанд тус бүр 1 ширхэг гар угаалтуур байхаар заасан байхад 0.1 сая төгрөгийн 1 угаалтуурыг байршуулаагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон;
- Өлзийт сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн замын тэмдэг, тэмдэглэгээ байршуулан гэрлэн чимэглэл хийх ажлын техникийн тодорхойлолтод заасан ажлаас засмал замын хажуу 20 ширхэг гэрэлтүүлгийн шонг 4 метрийн урттай урсдаг гэрлээр чимэглэх, доод талыг нь фосфортдог наалтаар наах 0.7 сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон;

Бууцагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн:

- Малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээс малчдыг чадавхжуулах үүднээс 1000 малчдын чуулга уулзалтад сумын малчдыг оролцуулахад 3.7 сая төгрөгийн хувцас, малгай авч өгсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8.1 дэх "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно гэсэн заалтын зөрчсөн;

Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн:

- Нутаг дэвсгэрийн нэгдсэн төлөвлөлтийн ажлыг 69.8 сая төгрөгөөр гүйцэтгэхээр "Голден мэл" ХХК 2023.07.07-ны өдөр сумын Засаг даргатай гэрээ байгуулж, гэрээний 2.2-т төлбөрийн хуваарийг тусгаж, ажлын гүйцэтгэлийн эцсийн тайлан, хүлээн авсан актаар баталгаажуулснаар 13.9 сая төгрөг буюу 20 хувийг олгохоор байхад тус төсөл арга хэмжээнд санхүүжилтийг бүрэн олгосон;
- Баян-Овоо сум Нарийн ногоон өвс бэлтгэн нийлүүлэх гэрээг Баян-Овоо сумын Засаг дарга, "Пэйс Роуд" ХХК-ийн захирал нар 2023.01.18-ны өдөр байгуулж, 2142 боодол өвсийг 2023.04.01-ний дотор нийлүүлэхээр гэрээнд тусгаж, 2023.02.01-ний өдөр 36.4 сая төгрөгийг шилжүүлсэн бөгөөд 2023 онд өвс нийлүүлээгүй, 2024.02.16-ны өдөр 812 боодол буюу 13.8 сая төгрөгийн өвсийг нийлүүлж, гэрээний дагуу нийлүүлэх 22.6 сая төгрөгийн 1330 боодол өвсийг нийлүүлээгүй;

Эрдэнэцогт сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн:

- Эрдэнэцогт сумын ОНХС-ийн хөрөнгөөр тайлант онд баталсан 1 төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүй, тус санхүүжилтээр 49.5 сая төгрөгийн баталгаагүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Монгол улсын сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 8.5 дахь "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2023 оны 278 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д зааснаар захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж, сум, дүүргийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтан нь бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийн эрхийг олгоно" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүйтэй холбоотой байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд үр дүн үзүүлж байгаа ч төлөвлөсөн зорилтот түвшинг бүрэн хангаагүй, зорилтот түвшинг тооцоолж дүгнэх үйл явцыг бүрэн хийхгүй байна.

Аудитаар төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, санхүүжилтийг илүү олгосон, санхүүжилтийг аваад ажлыг гүйцэтгээгүй орхигдуулсан нийт 106.9 сая төгрөгийн 10 зөрчилд төлбөрийн акт тогтоож, ажлыг дутуу буюу чанаргүй гүйцэтгэсэн 132.3 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах хугацаатай 7 албан шаардлагыг хүргүүлж ажиллав.

Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээг гэрээний дагуу санхүүжүүлэх, гэрээний биелэлт, ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй, ажлыг хүлээн авах ажлын хэсгийн ажлын хариуцлагагүй байдлаас дээрх зөрчил гарч байгааг цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

2.2. Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээнээс сумдад эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.

2.2.1. Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээнээс аймгийн Засаг даргын 14 удаагийн захирамжаар 2,025.9 сая төгрөгийн 39 төсөл арга хэмжээг сумдад эрх шилжүүлж, эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т даалгасан байхад хяналтыг хэрэгжүүлэн ажиллаагүйгээс 2 төсөл хөтөлбөрийн үр дүн хангалтгүй байна.

Аудитын илрүүлэлт

- Баянхонгор аймгийн ОНХС-аас эрх шилжүүлэн 79.9 сая төгрөгөөр санхүүжүүлсэн Баянбулаг сумын төвийн халуун усны барилгыг цэвэр усны шугамд холбох ажлыг хангалтгүй гэж дүгнэсэн;
- Баянхонгор аймгийн ОНХС-аас эрх шилжүүлэн олгосон Баянговь сумын сургуулийн дотуур байрны их засварын ажил, Жинст сумын ЗДТГ-ын их засвар, Баацагаан соёлын төвийн засвар, Эрдэнэцогт сумын Өвгөнжаргалант багийн төвийн засвар, Галуут сумын дотуур байрны их засвар, Баянцагаан сумын сургуулийн спорт заалны их засвар зэрэг ажлуудын чанар байдлыг ашиглагч байгууллагуудаас дунд гэж үнэлсэн байна.

Иймд цаашид аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр сумдад эрх шилжүүлэн хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн хяналтыг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ээс тавьж, ажлын хэсэгт орж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд аймаг, сумд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний сайн жишээ:

Баянхонгор аймаг:

- ✓ Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар цахилгааны эх үүсвэрийн чадлыг 6кВт-аас 10кВт-т шилжүүлэхэд шаардлагатай 26 трансформаторийг байршуулах ажил хийгдэж байгаа бөгөөд тус ажлын үр дүнд аймагт амьдарч байгаа иргэдийн цахилгааны баталгаат эх үүсвэрийг хангах;

Баянхонгор сум:

- ✓ “Хог хаягдлыг бууруулах Эко кэйш машиныг худалдан авах” төсөл, арга хэмжээнд 20.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд Баянхонгор сумд байрлуулж хог хаягдлыг худалдан авах боломжтой болсон. Тус машин нь Монос, Витафит, Таван богд групп, Green gate, Pepsi, MCS, “Сүү” ХК, АПУ, Хужирт зэрэг компаниудын бүтээгдэхүүний саван дээрх QR кодыг уншуулснаар хог хаягдлыг хүлээн авдаг.
- ✓ “Зөөврийн усан сангуудыг ухаалаг болгох” төсөл, арга хэмжээнд 160.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд гэр хорооллын иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, цаг хугацааг хэмнэсэн, орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн ажил болсон.

Галуут сум:

- ✓ “Стандартын шаардлага хангасан халуун ус, нийтийн 00 барих” төсөл, арга хэмжээнд 147.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд сумын ард иргэд эрүүл ахуйн шаардлагад нийцсэн орчинд үйлчлүүлэх боломж бүрдэхийн зэрэгцээ ажлын байрыг бий болгосон.

Заг сум:

- ✓ Заг сумын ОНХС-ийн хөрөнгөөр 19.8 сая төгрөгөөр Соёлын төвд байгаль, амьтны музейтэй болох ажлыг хийж гүйцэтгэснээр иргэд, хүүхэд багачуудын соёлын мэдлэг дээшилж, орлого нэмэгдэх боломжтой болсон;

Жаргалант сум:

- ✓ Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгийн 10.0 сая төгрөгөөр халуун усны барилгын засварласнаар ажлын байр нэмэгдсэн;
- ✓ Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөс “Эрэн хайх аврах салбарын авто машины гراج”-ийн ажилд 20.0 сая төгрөгийг баталж, албан хаагчдын оролцоотойгоор 2 автомашины гراج барьсан байна.

Хүрээмарал сум:

- ✓ Хүрээмарал сумын ОНХС-ийн хөрөнгөөр Энергийн төвийг түшиглэж аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээнд 59.0 сая төгрөгөөр жуулчны баазыг барьснаар цаашид аялал жуулчлал хөгжиж, орон нутгийн орлого нэмэгдэх боломж бүрдсэн.


Баянцагаан сум:

- ✓ Баянцагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн “4, 5 дугаар багийн төв барих” төсөл, арга хэмжээнд 300.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд багийн төв болон ахмадын өргөөг нэг дор шийдсэн, ариун цэврийн байгууламж, дэд бүтэц нь орчин үеийн стандартад нийцсэн нь сумд хэрэгжсэн сайн жишээ болсон байна.

Аудитын судалгаагаар Баянхонгор аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний чанар байдлыг ашиглагч байгууллагаас 84.8 хувийг сайн, 13.9 хувийг дунд, 1.3 хувийг муу гэж үнэлсэн байна.

Харин Баянхонгор аймгийн иргэдээс авсан санал асуулгын дүнгээр ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, чанарыг 29.7 хувь нь Сайн, 50.7 хувь нь Дунд, 6.4 хувь нь Хангалтгүй гэж үнэлсэн байна.

Та Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, чанарт ямар үнэлгээ өгөх вэ?



Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөс ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээнд 1,099.9 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд тус арга хэмжээг хэрэгжүүлснээр аймгийн хэмжээнд түр болон байнгын ажлын байр хэдээр нэмэгдсэн талаар аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нэгдсэн судалгааг гаргаж, үр дүнг тооцож ажиллаагүй байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг бүрэн санхүүжүүлсэн атлаа түүний үр дүнг тооцоогүй, зорилтот түвшинд төлөвлөсөн арга хэмжээ

хүрээгүй байхад арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн Баянхонгор сумын Оточ номгон өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг ашиглагч байгууллагаас "замын хайрга хөрс нь доош цөмөрсөн, ус зайлуулах суваг цооног байхгүй, борооны үеэр подвол руу ус ордог, ариун цэврийн өрөөний агааржуулалтын шугамаас бохирын үнэр тогтмол үнэртэж байгаа" гэсэн гомдлыг ирүүлсэн;
- Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгээс "барилгад хийгдсэн борооны ус зайлуулагчийн холбоосоор ус гоожиж, барилгын хана болон үүдний шат руу урсаж байгаагаас үүдний шатны плита ховхорсон", барилгын засварын явцад гарсан хог хаягдлыг цэцэрлэгийн хашаанд асгасныг цэвэрлээгүй" гэсэн гомдлыг ирүүлсэн;
- Баянхонгор сумын 514 дүгээр байрны их засварын ажлыг аудитаар шалгахад орцны будаа ховхорсон, чанаргүй хийгдсэн;
- Баян-Овоо сумын Соёлын төвийн номын санд тохижилт хийх бараа материал нийлүүлэхээр "Асгамба сүмбэр" ХХК 2023.02.01-ний өдөр Баян-Овоо сумын Засаг даргатай 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаатай гэрээ байгуулж, 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдөр 8.6 сая, 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр 11.4 сая төгрөгийг тус аж ахуйн нэгжид шилжүүлсэн байхад ажлыг хийж гүйцэтгээгүй;
- Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Голден эко арт" ХХК-ийн гүйцэтгэж байгаа жишиг гудамжинд айлууд буусан хашааны үнэнд тушаасан 14.4 төгрөгийг сумын ОНХС-д төвлөрүүлэлгүй, сумын төсөвт байгууллагуудын хашааны үнэнд зарцуулсан;
- "Арслант хүлэг" ХХК 2023.02.01-ний өдөр Сумын нөөцөд хивээ, өвс бэлтгэн нийлүүлэх гэрээг байгуулж, 2023.04.01-ний өдрөөс өмнө 35.0 сая төгрөгийн 1000 боодол өвс, 1000 шуудай хивээ нийлүүлэх гэрээг байгуулж, 2023.02.09-ны өдөр 12.0 сая, 2023.03.02-ны өдөр 12.0 сая төгрөгийг шилжүүлсэн байхад гэрээний үүргээ биелүүлээгүй байна. Тус ААН-тэй 2023.05.01-ний өдөр нэмэлт гэрээ байгуулж, 2023.05.31-ний өдөр 812 шуудай өвс, 684 боодол улаан хивээ нийлүүлэх 26.0 сая төгрөгийн гэрээ байгуулан, 2023.05.16-ны өдөр санхүүжилт, нийт 50.0 сая төгрөгийг б олгосон байхад өвсийг хүлээлгэн өгөөгүй;
- Баян-Овоо сумын Музейн тохижилтын тавилга нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт шалгарсан "Ерөөл нэмэх" ХХК орчин үеийн шаардлагад нийцсэн гадна талын 1 ширхэг камерыг суурилуулаагүй, 8 өрөө тус бүрд гэрэл сайтай гэрэлтүүлгийг дутуу хийж гүйцэтгэсэн, үзэгчдийг хүлээн авах танхимын текийн арын бичгийг хийгээгүй, 2.5х2.5 метрийн урттай 2 ширхэг сумын хөгжлийн макет, 23.2 сая төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй;
- Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны засвар ажлыг гүйцэтгэгч "Могойн хөндий" ХХК нь гимнастикийн болон спорт авиралтын зориулалттай, модон, олсон материалтай хананд тогтоодог 2 ширхэг ханын шатыг хийж гүйцэтгээгүй байна. Баян-Овоо сумын цэвэр усны шугам тавих 98.5 сая төгрөгийн ажлыг "Могойн хөндий" ХХК гүйцэтгэхээр 2023.07.04-ний өдөр гэрээ байгуулсан бөгөөд аудитаар хийсэн ажлыг техникийн тодорхойлолттой тулган шалгахад 8.6 сая төгрөгийн иргэний танхимд эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөө, гар угаалтуурын хамт суурилуулж, ашиглалтад оруулах ажлыг хийж гүйцэтгээгүй;
- Баянхонгор сумын Засаг даргын 2023 оны 03 сарын 10-ны өдрийн А/51 тоот захирамжаар Баянхонгор сумын нутаг дэвсгэрт 100 өрхийг хүлэмжийн аж ахуй эрхлэх ажлыг зохион байгуулж иргэнтэй байгуулсан гэрээнд иргэдийн тарьж ургуулсан ногоог хэрхэн борлуулах, өрхийн

орлогын өсөлтийг яаж тооцох, иргэд хоорондоо хүлэмжээ дамлан худалдахгүй байх зэрэг асуудлыг тодорхой үнэлэх боломжтойгоор тусгаагүй;


- Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Голден эко арт" ХХК-ийн гүйцэтгэж байгаа жишиг гудамж хорооллын 4 тал хашааны үнийг сумын ЗДТГ-аас 5.7 сая, 3 тал хашааны үнийг 4.2 сая төгрөгөөр тогтоосон, цаашид тус гудамжинд ямар журам баримтлах нь тодорхой бус байна.

Цаашид гэрээний үүргийг хэрэгжилтийг дүгнэх, хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд тооцох алданги, ажлыг хүлээн авч байгаа ажлын хэсэг техникийн тодорхойлолтод заасан ажил тус бүрээр ажлыг хүлээн авах, санхүүжилтийг гэрээнд заасны дагуу гүйцэтгэлд үндэслэн олгох зөвлөмжийг хүргүүлж ажиллав.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитой тодорхойлоогүй 11 зөрчилд 116.2 сая төгрөгийн зөрчил илэрч, үүнээс 84.4 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 31.8 сая төгрөгийн 8 зөрчилд албан шаардлага өгөв.

Аудитын явцад авсан санал асуулгад оролцогчдоос “Та орон нутгийнхаа 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон төсөл арга хэмжээний талаар мэдэх үү” гэсэн асуултад 30.3 хувь нь сайн мэднэ гэж хариулсан бол 50.8 хувь нь зарим төсөл арга хэмжээг, 12.8 хувь нь огт мэдэхгүй гэж хариулсан байгаагаас харахад иргэд мэдээ, мэдээллийг тодорхой хэмжээгээр авч байгааг харуулж байна.

Танай орон нутагт орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр бий болсон бүтээн байгуулалт, хөрөнгийн ашиглалтад та ямар үнэлгээ өгөх вэ?



Сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн ашиглалтыг санал асуулгад оролцогчийн 30.1 хувь нь Сайн, 51.1 хувь нь Дунд, 4.2 хувь нь Хангалтгүй гэж үнэлжээ.

2.2.2. Сангийн хөрөнгөөр хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээг олон жил дамжин хэрэгжихээр баталсан, сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг цаашид хэрхэн ашиглах талаар журам боловсруулаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баян-Овоо сумын Засаг дарга, "Голден эко арт" ХХК-ийн захирал нар "Баян-Овоо сумын "Жишиг гудамж хороолол барих" ажлыг 175.1 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээг 2022 онд байгуулан, хийж дуусгаагүй бөгөөд тус ажлын нэгжийн гүйцэтгэж байгаа жишиг гудамж хорооллын цаашид ямар журам баримтлан иргэдийг суурьшуулах нь тодорхой бус байна;
- Баян-Овоо сумын Орон нутгийн барилгын их засварын ажлыг 1,549.4 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр "Буянт хөрс наран" ХХК-тай 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдөр гэрээ байгуулж, тус төсөл арга хэмжээнд 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөс 300.0 сая төгрөгийг баталж, шилжүүлсэн байхад хашаа барьснаас өөр ажил хийгээгүй, тус ажлыг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр ашиглалтад өгөхөөр гэрээнд заасан боловч 2024 онд үлдэгдэл санхүүжилт бүрэн батлагдаагүй байгаа нь төсвийн үр ашиг саарах, төсөвт өртөг нэмэгдэх, төсөл арга хэмжээ чанаргүй хийгдэх эрсдэлтэй байна.

Төсөл, арга хэмжээ он дамжин удааширснаар иргэд, олон нийтийн үр өгөөж хүртэх хугацаа хойшлох, үр өгөөж саарах эрсдэлтэй тул цаашид дээрх зөрчлийг арилгах албан шаардлагыг сумын удирдлагуудад хүргүүлж ажиллав.

2.3. ОНХС-ийн хөрөнгийн санхүүжүүлсэн мод, суулгац тарих ажлын усалгааны асуудлыг бүрэн шийдээгүйгээс ургалтын байдал хангалтгүй байна.

2.3.1. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 273.8 сая төгрөгийн 6 нэр төрлийн хөрөнгийг ашиглаагүй байгаа нь төсвийн үр ашгийг бууруулж байна.

Аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр бэлтгэсэн 2, Өлзийт сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 2, Бөмбөгөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 1, Баянговь сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 2, нийт 286.6 сая төгрөгийн 7 нэр төрлийн хөрөнгийг ашиглаагүй зөрчил аудитаар илэрсэнд сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг ашиглаж, үр дүнг сайжруулах албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт:

- Багийн Засаг дарга нарыг техник хэрэгслээр хангах зорилгоор Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөс “Саммит компьютер технологи” ХХК-аас 60.2 сая төгрөгийн 74 ширхэг HP Laser MFP 135W маркын принтерийг худалдан авсан боловч 2024.06.14-ний байдлаар хөрөнгийг тавьж олгоогүй;
- Өлзийт сумын ОНХС-ийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 38.0 сая төгрөгийн өртөг бүхий ажлын байр дэмжих тоног төхөөрөмж худалдан авах, 20.0 сая төгрөгийн өртөг бүхий нийтийн 00 зэргийг ашиглаагүй;
- Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Шинэ суурьшлын бүсийн хамгаалалтын ойн зурвасын усалгааны материалыг 93.7 сая төгрөгөөр худалдан авсан боловч 30 хувь буюу 12.8 сая төгрөгийн бараа материал “Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ”-т ашиглалтгүй үлдэгдлээр, агуулахад хураалттай байна.
- Баянговь сумын ОНХС-аас 115.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нийт 385.6 сая төгрөгийн өртөг бүхий “Хөгжлийн төвийн барилга”, 20.0 сая төгрөгийн өртөг бүхий “Хөгжлийн төвийн тоног төхөөрөмж”-ийг ашиглаагүй байна.
- Бөмбөгөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 20.0 сая төгрөгийн өртөг бүхий “Хөх толгойн 2-р багт эрчим хүчний өргөтгөл” төсөл, арга хэмжээг ашиглаагүй байнга.

2.3.2. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөс “Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах” чиг үүргийн хүрээнд Баянхонгор аймгийн хэмжээнд нийт 3,151.5 сая төгрөгийн 130 төсөл арга хэмжээ хэрэгжсэн боловч мэргэжлийн болон эзэмшигч байгууллагын хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлиг, 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 58 дугаар зарлиг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2023 оны А/252, А/537 дугаар захирамжийн дагуу “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор мод, суулгац тарих ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр мод, суулгац тарих ажлын техникийн тодорхойлолтод тарих модны төрөл, насыг нарийвчлан заагаагүй, усалгааны асуудлыг бүрэн шийдээгүйгээс модны ургалтын байдал хангалтгүй, модны ургалтын хувийг тогтоогоогүй байна. Сангийн хөрөнгөөр хийгдэх ажлыг “Багц” нэрээр тодорхойлж, хийгдэх ажлын өртөг, тоо хэмжээг тодорхой тусгаагүйгээс төсвийн хөрөнгө үргүйдэх эрсдэлтэй бөгөөд аудитаар тулган шалгахад хүндрэлтэй байдлыг үүсгэж байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн ОНХС-ын хөрөнгөөр “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр Баянхонгор сумын Эрдэнэмандал хайрхны 3 га талбайд мод тарьж ургуулах төсөл арга хэмжээг гүйцэтгүүлэхээр “Их хайрханы хаялага” ХХК-тай гэрээ байгуулан санхүүжилтийг олгохдоо гэрээний тусгай нөхцөлийг зөрчиж санхүүжилтийг бүрэн олгосон, ажлын даалгаварт тусгагдсан 3 жилийн хугацааг гэрээнд нэг жилээр тусгасан, мод, сөөг тарьж ургуулах 3 жилийн төсвийн тооцоонд усалгааны систем суулгаагүй, модны арчилгаа усалгааг гараар гүйцэтгэхээр төсвийн задаргаанд тусгасан нь модыг 3 жилээс цаашид арчлах ажилд нэмэлт төсөв шаардагдахаар үр ашиггүй гэрээ байгуулсан;
- “Түйн голын төгөл” ХХК нь Баян-Овоо сумын нутагт орших аймгийн хуучин хогийн цэгийн 1 га талбайд 19.9 сая төгрөгийн биологийн нөхөн сэргээлт хийж, мод тарьсан байхад ХБТХОХ-ээс хяналт тавьж, ургалтын хувийг тогтоогоогүй, аудитаар модны ургалт, арчлалт хамгаалалт хангалтгүй;
- Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэцогт сумын ОНХС-аас 20.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, модны усалгаа, арчилгааг хариуцсан эзэн байхгүйгээс модны ургалт хангалтгүй байна.

Иймд цаашид ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ техникийн тодорхойлолтод тарих мод, ургамлын нас, тоо ширхэг, төрөл, үнийг нарийвчлан тусгах, тариалсан газрын усалгааны системийг бүрэн шийдвэрлэн тусгаж, техникийн тодорхойлолтыг мэргэжлийн байгууллагаар хянуулж батлуулж байх зөвлөмжийг аймаг, сумдын Засаг дарга нарт хүргүүлж, аудитаар илэрсэн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

БҮЛЭГ 3. АЙМАГ, СУМДЫН ИТХ, ЗДТГ-УУД ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТЫГ ТАВЬЖ, ТАЙЛАГНАХ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

3.1. ОНХС-ийн үйл ажиллагаанд бүх шатны ИТХ-аас төсөл, арга хэмжээний хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.1.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 4 сумын ОНХС-ын үйл ажиллагаанд хяналт хийсэн бол Аймгийн ИТХ болон 10 сумын ИТХ хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий аймаг, сумдын ИТХ-ын хяналт хийх хороод 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4¹⁷ дэх заалтыг зөрчсөн ба журмын 9.5¹⁸, 9.6¹⁹-т заасан чиг үүргийн аймаг, сумдын ЗДТГ-ууд бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байгаа тул бүх шатны ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх зөвлөмжийг хүргүүлэв.

Баянхонгор аймгийн СХДАА-наас 2023 онд аймаг, сумдын ОНХС-ийн зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд хяналт шалгалт хийгээгүй, 2024 оны 03 дугаар улиралд аймаг, сумдын ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт хийхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу сумдын төсөвт байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ Өлзийт, Шинэжинст, Баянбулаг, Баян-Өндөр сумдын ОНХС-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж, шалгалтаар 276.4 сая төгрөгийн 7 зөрчил илэрсэнд 215.9 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага өгч, 60.5 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн, хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна.

3.1.2. Сумдад эрх шилжүүлсэн болон сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхдээ мэргэжлийн байгууллагаар хянуулаагүйгээс хяналтын үр дүн хангалтгүй байна.

¹⁷ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм" болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

¹⁸ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засагийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 206 дугаар тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд жил бүр хийнэ.

¹⁹ Энэ журмын 9.5-д заасны дагуу хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлэх үүргийг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар хүлээнэ.

Аудитаар авсан судалгаагаар аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 20,940.9 сая төгрөгийн 522 төсөл арга хэмжээнээс 89.1 хувь буюу 465 төсөл арга хэмжээнд нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, 10.9 хувь буюу 57 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Хэрэгжүүлээгүй төсөл арга хэмжээний 34 нь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр, 8 нь Баянбулаг, 3 нь Хүрээмарал, 12 нь Шинэжинст сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг тухай бүрд, бүрэн хэрэгжүүлээгүйгээс 6 суманд 90.1 сая төгрөгийн ажлыг хүлээн аваагүй, холбогдох журмыг мөрдөж ажиллаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянбулаг сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн “Халуун усны засвар” хийх ажлыг гүйцэтгэхээр “БИ БИ ДИ ЭМ” ХХК-тай 79.6 сая төгрөгийн гэрээ байгуулж, 40.0 сая төгрөгийг олгосон бөгөөд уг ажлыг холбогдох журмын дагуу хүлээн авч, акт үйлдээгүй;
- Бөмбөгөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийх Жижиг дунд үйлдвэрлэлийн барилгатай болох 120.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээг “Чандмань Бөмбөгөр” ХХК-тай 115.0 сая төгрөгийн гэрээ байгуулахдаа ажил дуусах хугацааг гэрээнд тусгаагүйгээс захиалагчийн хяналт хэрэгжүүлэх боломжгүй байна.
- Галуут сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн “Аянга зайлуулагчтай болох” ажлыг гүйцэтгэхээр “Скейл” ХХК-тай 20.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, 14.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд уг ажлыг холбогдох журмын дагуу хүлээн авч, акт үйлдээгүй;
- Гурванбулаг сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн эко нойл 5.2 сая төгрөгөөр гэрээ байгуулан, санхүүжилтийг авсан боловч хугацаандаа ашиглалтад оруулаагүй;
- Заг сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн “Сумын гудамж хорооллын гэрэлтүүлгийн өргөтгөл” хийх ажлыг гүйцэтгэхээр “Их хотын гэрлэн дохио” ХХК-тай 17.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, 13.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байхад хүлээн аваагүй;
- Заг сумын ОНХС-ийн хөрөнгөөр иргэн П.Мягмарсүрэнгийн 17.9 сая төгрөгөөр гүйцэтгэсэн “Соёлын төвд байгаль ан амьтны музейтэй болох” хийх ажлыг холбогдох журмын дагуу хүлээн авч, акт үйлдээгүй байна.
- Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гэрээнд ажлыг заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хариуцлага тооцох, алданги төлүүлэх талаар тусгаагүй байна.
- Сумдын ОНХС-аар малын үүлдэр угсааг сайжруулах арга хэмжээний хүрээнд худалдан авсан мал амьтдын гарал үүсэлд хяналт тавих асуудал тодорхойгүй бөгөөд Мал эмнэлэг, ХХААГ нь хоорондын ажлын уялдаа муу, бие бие рүүгээ түлхсэн байдлаас үүдэж 2023 онд Баян-овоо суманд шүлхий, 2024 оны 1-р улиралд Богд суманд хонины цэцэг өвчин гарах шалтгаан нөхцөл болсон байна.

Иймд дутуу хийгдсэн ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж хүлээн авах албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, Баянбулаг, Галуут, Гурванбулаг, Заг сумын Засаг даргад хүргүүлж байна.

Малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээр сумууд малын үүлдэр, угсааг сайжруулах чиглэлээр мал амьтан худалдан авч байгаа хэдий ч аудитаар гарал үүслийн гэрчилгээг аваагүй, энэ талаар аймгийн ХХААГ-аас тодруулсан боловч хариу ирүүлээгүй, аймгийн Мал эмнэлгийн газарт мал амьтдын бүртгэл хийгдээгүй байна.

Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэж байгаа эцэг малын гарал, үүсэл, түүнд тавих хяналтыг ажил үүргийн хуваарийн дагуу гүйцэтгэж байх зөвлөмжийг аймгийн Мал эмнэлэг, Хүнс хөдөө аж ахуйн газарт, нэгдсэн бодлогоор хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т тус тус хүргүүлэв.

3.1.3. Төрийн аудитын байгууллагаас 2023 онд гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2022 онд гүйцэтгэсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар нийт 3,710.8 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 41.5 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 2,966.0 сая төгрөгийн зөрчилд 19 албан шаардлага хүргүүлж, 703.3

сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өгсөн аудитын шийдвэр бүрэн биелсэн байна.

Өмнөх аудитаар илэрсэн ТБХНӨХБАҮХАТХ-ийг зөрчсөн, иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээ баталсан, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй, Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн оруулаагүй зөрчлүүд дахин илэрч байна.

Санхүүгийн тайлангийн 2024 оны аудитаар аймаг сумдын ОНХС-д 1,816.6 сая төгрөгийн 30 зөрчил илэрснээс 71.0 сая төгрөгийн 7 төлбөрийн акт, 1,602.4 сая төгрөгийн 20 албан шаардлага, 143.2 сая төгрөгийн зөрчил давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлсэн ба 2024 оны эхний хагас жилийн байдлаар төлбөрийн актыг 42.8, албан шаардлагыг 80.0, зөвлөмжийг 66.6 хувиар биелүүлсэнд төрийн аудитын байгууллагаас холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээ, бодлогыг тодорхойлж ажиллахгүй байна.

3.2.1. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр бүлэгт ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг хүргэх, тайланд тусгах мэдээллийг дараах байдлаар зохицуулсан байна.

Хүснэгт 3. Тайлан хүргүүлэх хугацаа, мэдээлэл

Хариуцах нэгж, албан тушаалтан	Тайлагнах хугацаа	Хүргүүлэх албан тушаалтан	Тайланд тусгах мэдээлэл	Тайланд дүн шинжилгээ хийж, хэрэгжүүлэх арга хэмжээ
9.2/9.3 заалт Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга	Дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор	Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг хүргүүлнэ.	9.9.1.ОНХС-ийн тухайн оны батлагдсан төсөв, санхүүжилт нь эх үүсвэр бүрээр; 9.9.2.ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт нь хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр; 9.9.3.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр, байршил, ажлын гүйцэтгэлийн хувь, эхлэх, дуусах хугацаа; 9.9.4.Шинээр бий болсон барилга байгууламж, гүйцэтгэсэн их засварын ажил, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн гэрэл зураг, тэдгээрийг өмчлөлд бүртгэснийг баталгаажуулсан баримт; 9.9.5.Он дамжин хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт; 9.9.6.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн сайн туршлага, жишээ, оновчтой санал; 9.9.7.Энэ журмын 9.4, 9.5-д дурдсан байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, дүгнэлт, акт болон албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга.	1. ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна. 2. Засаг даргын шийдвэрийг тухайн шатны ИТХ-аар жил бүр, төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн талаарх Засаг даргын мэдээллийн хамт хэлэлцүүлнэ.
9.9/ 9.10 заалт Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг хүргүүлнэ.		Тайланд дүн шинжилгээ хийж, ОНХС-ийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр бодлого боловсруулна.

Эх сурвалж: 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”

Сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нар сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн тайланг албан бичгээр гаргаж ирүүлээгүй байгаа нь журмын²⁰-т заасныг зөрчсөн байна.

²⁰ Журмын 9.2 дахь заалт: Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.9²¹-т заасныг мөрдөж аймгийн ХБТХОХ нь Сангийн яаманд албан бичгээр хүргүүлж ажиллаагүй, сумдаас зөвхөн судалгааны түвшинд файлыг авч, цахимаар илгээсэн гэх боловч хэзээ хүргэгдсэн эсэх нь аудитаар нотлогдохгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь сумдаас ирүүлсэн хэрэгжилтийн тайланд журмын 9.3-т заасны дагуу тайлангуудад дүн шинжилгээ хийж, журмын 9.9-т заасан мэдээллийг бүрэн тусгаж, дүн шинжилгээнд тулгуурлан цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулж ажиллаагүй байгаа нь журмыг²² зөрчсөн байна.

Иймд сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний тайланг нэгтгэн дүн шинжилгээ хийж тайланг Сангийн яаманд албан бичгээр хүргүүлж байх, шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулж байх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т хүргүүлэв.

3.2.2. Аймаг, сумын ОНХС-ын хөрөнгөөр тайлант онд бүрэн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 1.7 хувийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Баянхонгор аймаг, сумдын дүнгээр 2023 онд сангийн хөрөнгөөр бий болсон нийт төсөл арга хэмжээний 36.8 хувь буюу 7,711.1 сая төгрөгийн хөрөнгийг төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгөд, 5.4 хувь буюу 1,131.6 сая төгрөгийн хөрөнгийг бараа материал дансанд бүртгэж, 20.5 хувь буюу 4,313.7 сая төгрөгийг урсгал зардлаар бүртгэжээ.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, аймгийн ОНӨГ-ын ажлын уялдаагүйгээс шалтгаалж 2023 онд аймгийн ОНХС-аар бий болсон хөрөнгийг орлогод авах ИТХ-ын даргын 25 тоот захирамжийг 2024.04.03-ны өдөр гаргасан байна.

Баянхонгор сум нь 2023 онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгөд өмчлөгч тогтоохдоо сумын ИТХ-ын хуралдааны 2024.04.17-ны А/108, 2024.04.22-ны 14/87, 2024.05.10-ны А/33 дугаар тогтоолуудаар 2024 онд орлогод авсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр “Шинэ суурьшлын бүс”, “Өлзийт МСҮТ”, “-ийн хойно нөөц газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийлгэх ажлыг “Гранд Амур” ХХК-тай 18.0 сая төгрөгөөр, “Дуурсах 3 дугаар багийн нутаг Ойн зурвасын хойно нөөц газар байр зүйн зураглал хийлгэх” ажлыг 6.6 сая төгрөгөөр тус тус гүйцэтгүүлсэн бөгөөд хөрөнгийг эзэмшигч тогтоож, орлогод аваагүй;
- Баянхонгор аймгийн ОНХС-аас 20.0 сая төгрөгийн санхүүжилт, Дэлхийн Зөн олон улсын байгууллагын 43.3 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн Сум дундын Ойн ангийн хашаанд өвсний тэжээлийн саравчийг барьж гүйцэтгэсэн байхад хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй;
- Баянхонгор аймгийн Засаг даргын 2023.11.29-ний өдрийн А/637 дугаар захирамжаар “Түйн голын төгөл” ХХК-ийн нийлүүлсэн 80.0 сая төгрөгийн 16,000 ширхэг ногоон тэжээл, 4,000 боодол нарийн өвс тэжээлийн зарцуулалтын анхан шатны баримт санхүүгийн баримтад байхгүй;
- Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйлчилгээний чанарыг сайжруулж, цахим мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэх ажлыг 25.0 сая төгрөгөөр “Айети юнипикишн” ХХК гүйцэтгэж, сервер компьютерыг хүлээн авсан бөгөөд аудитын биет шалгалтаар Үндэсний дата төвд шилжүүлсэн гэсэн тайлбарыг өгсөн боловч тус төвд шилжүүлсэн баримтыг удаа дараа шаардсан боловч хариу ирүүлээгүй;
- Баянхонгор аймгийн ЗДТГ-ын дарга, “Анарсистемс” ХХК-тай 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр “Баянхонгор и-оффис баримт бичиг төлөвлөлт, удирдлагын систем хөгжүүлэх гэрээ”-г байгуулж, удирдлагын системийг 20.0 сая төгрөгөөр гүйцэтгэж, 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр хүлээн авсан байхад нягтлан бодох бүртгэлд тусгаагүй;
- Эрдэнэцогт сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 12.5 сая төгрөгийн сумын нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөөг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй;

²¹ “Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг тусгана”

²² Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр гаргаан, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна.

- Эрдэнэцогт сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн сургуулийн 320 хүүхдийн шинэ барилгын 34.0 сая төгрөгийн өртөг бүхий ТЭЗҮ, зураг төсвийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй;
- Эрдэнэцогт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/151 дүгээр захирамжаар нэг бүр нь 1.1 сая төгрөгийн 2 ширхэг нарны толийг орлогод авахаар заасан байхад нэг ширхгээр орлогод бүртгэсэн;
- Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр малын үүлдэр угсаа сайжруулах 35.0 сая төгрөгийн гэрээг “Гэгээн шавь” ХХК 2023.09.18-ны өдөр байгуулж, махны чиглэлийн 10 тооны бухыг 2023.10.10-ны өдөр хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч бух хүлээн авсан актыг үйлдээгүй, хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, малчинд гэрээгээр хүлээлгэж өгөөгүй;
- Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр малын үүлдэр угсаа сайжруулах 48.5 сая төгрөгийн гэрээг иргэн Ч.Бат-Эрдэнэтэй 2023.10.18-ны өдөр байгуулж, махны чиглэлийн 66 тооны хуц, ноолуурын чиглэлийн 56 ухныг нэг бүрийг нь 0.4 сая төгрөгөөр 2023.11.13-ны өдөр хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч малыг хүлээн авсан актыг үйлдээгүй байна.
- “Эрдэнэмандал хайрханы өврийн төрийн байгууллагуудын авто зогсоол байгуулах” ажлын гэрээг 64.3 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр “Унага трейд” ХХК-тай байгуулсан бөгөөд ажлын гүйцэтгэлээр хэмнэгдсэн 5.1 сая төгрөгийн хайс, хашлагын зарцуулагдаагүй үлдэгдлийг орлогод аваагүй байна.


Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5²³, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4²⁴, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2²⁵-т заасныг тус тус зөрчсөн дээрх 305.8 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага хүргүүлэв.

3.2.3. Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулаагүйгээс иргэд, олон нийт мэдээллийг тухай бүрд авч чадахгүй байна.

Иргэний хувьд удирдлагын мэдээллийн системээс өөрийн болон бусад аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжсэн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй авах боломжийг олгож байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд 25,252.2 сая төгрөгийн 591 төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд оруулахаас нийт мэдээллийн 86.9 хувийг бүрэн, 8.2 хувийг дутуу оруулж, мэдээллийн 4.9 хувийг удирдлагын мэдээллийн системд огт оруулаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн “Удирдлагын мэдээллийн системээс ямар төрлийн мэдээлэл авдаг вэ?”



Аудитын явцад Баянхонгор аймгийн иргэдээс авсан санал асуулгын “ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системээс ямар мэдээлэл авдаг вэ” гэсэн асуултад 32.6 хувь нь мэдээлэл авдаггүй гэж хариулсан ба 27.9 хувь нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, биелэлттэй холбоотой, 14.6 хувь нь сангийн хөрөнгийн төлөвлөлттэй холбоотой, 9.1 хувь нь худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг авдаг гэж хариулсан байна.

Галуут, Богд, Өлзийт, Шинэжинст сумд ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд бүрэн мэдээлсэн байхад дараах сумд 751.5

²³ Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: хариуцлагаатай байх

²⁴ Аж ахуйн нээж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна

²⁵ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна

сая төгрөгийн 29 төсөл арга хэмжээний мэдээллийг системд мэдээлээгүй орхигдуулсан, 3,320.4 сая төгрөгийн 48 төсөл, арга хэмжээний мэдээллийг системд дутуу мэдээлсэн байна.

Аудитын илрүүлэлт

- Баянхонгор сум 5, Баян-Овоо сум 2, Баянговь сум 2, Гурванбулаг сум 5, Жаргалант сум 2, Заг сум 3, Баацагаан сум 1, Баянбулаг сум 9 төсөл арга хэмжээг Удирдлагын мэдээллийн системд огт мэдээлээгүй;
- Баянхонгор сум 4, Баян-Овоо сум 5, Бууцагаан сум 7, Жинст сум 3, Баянлиг сум 7, Гурванбулаг сум 2, Жаргалант сум 2, Заг сум 1, Бөмбөгөр сум 3, Хүрээмарал сум 3, Баянбулаг сум 1, Баян-Өндөр сум 5, Баянцагаан сум 3, Баянхонгор аймаг 2 төсөл, арга хэмжээг Удирдлагын мэдээллийн системд дутуу мэдээлсэн байна.

ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд мэдээллийг оруулж байгаа албан хаагчдын ажлын хариуцлагаас шалтгаалж, мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв оруулахгүй байх, төсөл, арга хэмжээний явцын болон эцсийн зургийг дутуу оруулах, өөр төсөл арга хэмжээний зургийг хавсаргах зэрэг 4,072.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд энэ нь Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10.3.2²⁶ дахь заалтыг мөрдөөгүйтэй холбоотой байна.

Иймд аймаг, сумын ОНХС-ийн зарцуулалтын гүйлгээг хийхдээ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10.3.2 дахь заалтыг хэрэгжүүлэх арга зүйгээр төрийн сангийн мэргэжилтнүүдийг хангаж, гарч буй зөрчлийг таслан зогсоож, 2023, 2024 оны мэдээллийг УМС-д бүрэн оруулах ажлыг зохион байгуулах албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэв.

3.2.4. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд аймаг, сумын ОНХС-ийн мэдээллийг байршуулаагүй зөрчил бүрэн арилаагүй байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ОНХС-ийн 2023 оны хөрөнгийн зарцуулалт, төлөвлөгөөг хангалтгүй мэдээлсэн байна.

Аудитын илрүүлэлт

- Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төлөвлөлтийг Галуут, Бууцагаан, Гурванбулаг, Баацагаан, Бөмбөгөр, Шинэжинст сумд хугацаа хоцроож мэдээлсэн;
- Баян-Овоо, Жинст, Богд сумд 2022 оны төлөвлөгөө, гүйцэтгэл оруулсан;
- Баянговь сум нь эхлэх, дуусах он тодорхойгүй мэдээлсэн;
- Эрдэнэцогт сумын ОНХС нь мэдээллийг байршуулаагүй байна.

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1²⁷ дэх заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудаст тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.1.15²⁸ дахь заалтыг тус тус зөрчсөн тул Баян-Овоо, Жинст, Богд, Баянговь, Эрдэнэцогт сумын ОНХС-ийн 2023 оны төлөвлөгөөг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 3,193.7 сая төгрөгийн төлөвлөгөөг нөхөж мэдээлэх 1 албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлж, аудитын явцад зөрчлийг арилгав.

²⁶ “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн ОНХС-ийн УМС-ийн хэрэгжилт цэсэд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д оруулж, оруулсан мэдээллийн дагуу санхүүжилтийг хийнэ”

²⁷ Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор

²⁸ Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор

Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийг сумд сар бүр мэдээлэхдээ Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1²⁹, 4.1.2³⁰ дахь заалтуудыг баримтлаагүйгээс дараах зөрчил нийтлэг илэрч байна. Үүнд:

- Санхүүжилтийн дүн, гүйцэтгэлийн хувийг бүрэн оруулаагүй;
- Төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийн регистр, гүйцэтгэгчийн нэрийг бүрэн оруулаагүй;
- Зарим сард мэдээллийг оруулаагүй, хугацаа хоцроож мэдээлсэн нь мэдээллийн ойлгомжтой, ач холбогдолтой байх зарчмыг алдагдуулж байна.

Баянхонгор аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гэрээг Галуут, Баян-Овоо, Бууцагаан, Жинст, Богд, Гурванбулаг, Жаргалант, Заг, Баацагаан, Хүрээмарал, Баянбулаг, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан сум болон Баянхонгор аймгийн ОНХС хариуцсан албан тушаалтнууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулаагүй зөрчилтэй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.9³¹, 6.4.8³² дэх заалт, “Шилэн дансны цахим хуудаст тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.1.7³³, 3.1.15³⁴ дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой тул аймаг, сумын ОНХС хариуцсан мэргэжилтнүүдэд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг үнэн зөв, бүрэн мэдээлж байх асуудалд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн СТСХ-т хүргүүлэв.

Аудитаар нийт 5,747.1 сая төгрөгийн 75 зөрчил илрүүлж, 201.3 сая төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт тогтоож, 5,200.8 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах 49 албан шаардлага өгч, 345.0 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар 10 зөвлөмж өгч, хариуцлага тооцох 2 албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

---oOo---

²⁹ Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх

³⁰ Мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх

³¹ Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл

³² Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор

³³ зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар

³⁴ Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийн сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 11 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. ОНХНС-аас Баянхонгор аймгийн ОНХС-д 15.405.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас 15,192.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, санхүүжилтийг баталсан хуваарийн дагуу шилжүүлээгүй байна.
2. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгийг олон жижиг төсөл, арга хэмжээнд зарцуулахаар баталж, санхүүжүүлж байгаа нь үр дүн багатай урсгал зардлын шинжтэй байна.
3. Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг Төсвийн тухай хууль, барилгын төсөв зохиох дүрмийн зөрчиж төлөвлөсөн байна.
4. Аймаг, сумын ИТХ-ын дэргэдэх хороод, аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтсээс ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, тайлагналд хяналт тавиагүй, техникийн тодорхойлолтыг мэргэжлийн байгууллагаар хянуулаагүйгээс сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, санхүүжилтийг аваад ажлыг гүйцэтгэхгүй байх, ажлыг дутуу буюу чанаргүй гүйцэтгэх, хийхгүй орхигдуулах зэрэг зөрчил давтан гарсаар байна.
5. Орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд ажлыг хүлээлгэн өгөх хугацаа, санхүүжүүлэх хуваарь, хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд тооцох алданги, хариуцлагын талаар тодорхой заагаагүй байна.
6. Аймаг, сумын төрийн сан ОНХС-ийн гүйлгээг хийхдээ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын дагуу хяналт тавиагүйгээс ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг хангалтгүй оруулж байна.
7. Аймаг, сумдын ЗДТГ-ууд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээ, бодлогыг тодорхойлж, аймгийн хэмжээнд мөрдөх нэгдсэн арга зүйг боловсруулж ажиллаагүй байна.
8. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр малын үүлдэр угсааг сайжруулах арга хэмжээний хүрээнд худалдан авсан мал амьтдын гарал үүсэлд хяналт тавих асуудал аймгийн Мал эмнэлгийн газар, ХХААГ-ын аль нь хариуцах нь тодорхойгүйгээр аймгийн хэмжээнд хаягдсан бөгөөд хүнсний аюулгүй байдалд эрсдэл дагуулж, малын халдварт өвчин тархаж төсөвт нэмэлт зардал гаргаж байна.
9. ТБХНӨХБАҮХАТХ-ийг зөрчин худалдан авах ажиллагааг зохион байгуулсан, иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээ баталсан, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй, Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн оруулаагүй зөрчлүүдэд өмнөх аудитаар зөвлөмжийг өгсөн байхад хэрэгжүүлж ажиллаагүйгээс зөрчлүүд давтагдан гарсаар байна.
10. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 344.0 сая төгрөгийн 10 хөрөнгийг нягтлан бүртгэлд тусгаагүй, сангийн хөрөнгөөр бий болсон 286.6 сая төгрөгийн 7 нэр төрлийн хөрөнгийг ашиглаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

АЙМГИЙН ИТХ-Д ТОЛИЛУУЛАХ НЬ:

1. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгийг олон жижиг төсөл, арга хэмжээнд зарцуулахаар баталж, санхүүжүүлж байгаа нь бусад бодлогын шинж чанартай хөрөнгө оруулалтын тайлан оны санхүүжилтийг багасгаж төсвийн үр ашиг буурахад нөлөөлж байна.
2. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх.

НЭГ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА

1. Аймгийн ОНХС-аар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулах, гарч буй зөрчлийг таслан зогсоох, зарим төсөл, арга хэмжээний *(Бууцагаан сумын Шинэ сумын барилгын засварын ажил, Баянхонгор сумын Эрдэнэмандал хайрхны Зга талбайд гоёлын мод, бут тарих)* тендер сонгон шалгаруулалтын үнэлгээний хорооны гишүүдэд хариуцлага тооцож ажиллах.

ХОЁР. АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН ДАРГА Т.ХИШИГБААТАРТ

2. Аймгийн ОНХС-аас эрх шилжүүлсэн болон сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн тусгай мэргэжил шаардсан төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтыг болон техникийн тодорхойлолтыг аймгийн холбогдох мэргэжлийн агентлагаар хийлгэх.
3. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланд “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.3, 9.9-т заасны дагуу дүн шинжилгээ хийж ажиллах.
4. Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэж байгаа эцэг малын гарал, үүсэл, түүнд тавих хяналтыг ажлыг зохион байгуулж, нэгдсэн бодлогоор хангаж ажиллах.

ГУРАВ. АЙМГИЙН ЗДТГ-ЫН СТСХ-ИЙН ДАРГА С.БАЙГАЛМААД

5. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.9 , 6.4.8 дэх заалт, “Шилэн дансны цахим хуудаст тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.1.7 , 3.1.15 дахь заалтыг хэрэгжүүлэх арга зүйгээр аймаг, сумын ОНХС хариуцсан мэргэжилтнүүдийг хангаж, Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг үнэн зөв, бүрэн мэдээлж байх асуудалд хяналт тавьж ажиллах.

ДӨРӨВ. БӨМБӨГӨР, БАЯН-ОВОО СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

6. Орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд ажлыг хүлээлгэн өгөх

хугацаа, санхүүжүүлэх хуваарь, хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд тооцох алданги, хариуцлагын талаар тодорхой тусгах.

ТАВ. БУУЦАГААН ЗАСАГ ДАРГА Д.ЛХАГВАДОРЖ ТАНАА

7. Сумын ОНХС-аар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулах, гарч буй зөрчлийг таслан зогсоох.

ЗУРГАА. АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛЭГ, ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА НАРТ

8. Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэж байгаа сайн үүлдрийн эцэг малын гарал, үүсэл, түүнд тавих хяналтыг холбогдох хууль, журамд заасны дагуу хэрэгжүүлж, мэдээллийн санг бий болгож ажиллах.